

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн тухай 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“13.4.Комиссын даргыг гишүүд дотроосоо олонхын саналаар сонгож санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа” гэснийг “олонхын саналаар нууц санал хураалтаар” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 13.4-т заасныг хүчин төгөлдөр хуулийн дагуу томилогдсон даргын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж, комиссын дараагийн даргыг томилох үйл ажиллагаанаас эхлэн дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн 2024 оны ... сарын ... өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Комиссын гишүүд даргаа өөрсдөө дотроосоо сонгох нь Комиссын хараат бус, бие даасан байдал бэхжих ач холбогдолтой. Иймд одоо үйлчилж байгаа Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурлаас томилж байгаа одоогийн зохицуулалтыг халж, Комиссын даргыг гишүүд дотроосоо олонхын саналаар сонгож Улсын Их Хуралд санал болгох зохицуулалтыг бий болгох, харин энэ нь одоогийн томилогдсон даргын бүрэн эрхийн хугацаанд хамааралгүй бөгөөд Комиссын дараагийн даргыг томилох үйл ажиллагаанаас эхлэн дагаж мөрдөхөөр тусгалаа.

Түүнчлэн Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт "Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн "Хүний эрх хамгаалагчийн хороо"-ны дарга байх бөгөөд Хорооны үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана" гэж, 13.6 дахь хэсэгт "Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнийг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно" гэж тус тус заажээ. Гэтэл Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт Комиссын гишүүнд нэр дэвшигч нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай, 35 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх ерөнхий шаардлагыг хангасан байхаар тусгасан.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс Хорооны гишүүнд хүний эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний, эсхүл олон улсын хэмжээнд долоогоос доошгүй жил ажилласан туршлагатай, хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо, эрх зүйн хэм хэмжээний талаар мэдлэг, туршлагатай, сүүлийн таван жил улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй байх шаардлагыг хангах, мөн хорооны гишүүнийг гурван жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгохоор заасан. Ийнхүү Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсэн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны дарга, гишүүнд тавигдах шаардлагыг эрхэлсэн ажил, албан тушаал, мэдлэг туршлага, цаг хугацаагаар нь ялгамжтайгаар заасан байна.

Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнийг тогтвортой ажиллуулах шаардлагаар хуульд заасан нэг жилээр ажиллах, нэг удаа сонгогдох зохицуулалтыг хасахаар тусгалаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ